

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт "Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно." гэж заасны дагуу Үндэсний баялагийн сангийн тухай хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал" /цаашид "аргачлал" гэх/-ын дагуу тооцло

Тусгагдсан зохицуулалттай уялдан зардал үүсгэх болон үүсгэж болзошгүй зүйл, заалтыг Хууль тогтоомжийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал"-ын дагуу судлалаа.

ХОЁР. АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

Хуулийн төслөөр иргэдэд шинээр үүрэг гүйцэтгэхийг даалгаагүй байх тул зардал үүсгэх зохицуулалт байхгүй байна. Шинээр татвар, зөвшөөрөл, нэмэлт бүртгэлийн асуудал үүсэхгүй тул аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй гэж үзлээ.

ГУРАВ. АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР

Хуулийн төслөөр хуулийн этгээдүүдэд шинээр үүрэг гүйцэтгэхийг даалгаагүй байх тул зардал үүсгэх зохицуулалт байхгүй байна.

Иймд аргачлалд заасны дагуу цаашид зардал үүсгэх эсэхийг тооцоолох шаардлагагүй бөгөөд Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль нь хуулийн этгээд, аж ахуйн нэгжүүдэд нэмэлт зардал үүсгэхгүй гэж үзлээ.

**ДӨРӨВ. АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛЬ БАТЛАГДСАНААР ТӨРД ҮҮСЭХ ЗАРДЛЫН ТАЛААР**

Хууль төсөл хэрэгжиж эхэлснээр шинээр татвар, чиг үүрэг төрд шинээр бий болохгүй.

-----oOo-----
